



**АРДЧИЛСАН НАМЫН
ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ХОРООНЫ
2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020 ОН



**ХЭНТИЙ АЙМГИЙН НОРОВЛИН СУМЫН АРДЧИЛСАН НАМААС
2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

ЗОРИЛГО:

Энэ удаагийн ИТХ-н сонгуульд Норовлин сумын иргэдийн эрүүл, аюулгүй, тав тухтай амьдарч, ажиллах нөхцлийг бүрдүүлэх, олон нийтийн оролцоо, иргэдийн дэмжлэгтэйгээр зохистой удирдлага, зохион байгуулалтыг бий болгох зорилтыг дэвшүүлж байна.

Бидний зорилт баримтлах зарчим

1. Амьдрах таатай орчин бүрдүүлэх
2. Төрийн үйл ажиллагааг ил тод, шуурхай явуулах
3. Ажлын байр нэмэгдүүлэх,
4. Нийгмийн хамгаалал, халамж үйлчилгээг сайжруулах,
5. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх

Бидний баримтлах зарчим

6. Сумын нутаг дэвсгэр дээр эмх цэгц, дэг журмыг тогтооход иргэдийн оролцоог нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллана.
7. иргэд өөрсдийн газартаа жижиг аж ахуй эрхэлж, хүнсний ногоо тарих замаар өөрсдийн аж амьдралыг дээшлүүлэхийг дэмжиж ажиллана.

Бидний уриа

Ардчилсан намын Хэнтий аймгийн Норовлин сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд “Иргэдийн оролцоо, Хөгжлийн түлхүүр” гэсэн уриатайгаар орж байна.

Зохистой засаглал, эрүүл амьдрал, нутгийнхаа хөгжлийн төлөө хамтдаа зүтгэе. Эх орондоо чөлөөт нийгэм, тэгш бололцоо, шударга ёсыг хэрэгжүүлэе.

ИТХ бүхий л үйл ажиллагаагаа иргэд сонгогчдод нээлттэй байж, хүнд суртлаас ангид, найрсаг үйлчилгээг бүрдүүлэх зорилт тавьж байна. Үүний тулд:

НЭГ. АМЬДРАХ ТААТАЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

- 1.1 Норовлин сумын хөгжлийн хөтөлбөр, хэтийн төлөвлөгөөг боловсруулан батална.
- 1.2 Газар зохион байгуулалтын төлөвлөлтийг батлуулж, хэрэгжүүлнэ.
- 1.3 Сумын төв доторх зам, дэд бүтцийн шугам сүлжээг төлөвлөж, газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу зам, гудамж, талбайг барьж байгуулна.
- 1.4 Сумын төвийн нутаг дэвсгэрт газар олгох, хуваарилах асуудлыг журамлаж, үйл ажиллагааг иргэдэд ил тод нээлттэй болгоно. Сумын төвийн нутаг дэвсгэрт иргэдэд газар өмчлүүлэх ажлын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
- 1.5 Иргэд амарч тухлах, чөлөөт цагаа өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэнг байгуулж, одоо байгаа цэцэрлэгт хүрээлэнг өргөтгөнө.



1.6 Сумын нутаг дэвсгэр, сумын төвийн гудамжийг цэвэр цэмцгэр байлгах тал дээр анхаарч байгууллага, оршин суугчид өөрсдөд харъяалагдах талбай, гудамжийг тохижуулан цэцэрлэгжүүлж, цэвэр цэмцгэр байлгах, өвлийн цагт цас, хальтаргаа гулгааг арилгаж хэвшихэд чиглэсэн журмыг батлуулж, хэрэгжүүлж ажиллана.

1.7 Суманд ахуйн үйлчилгээний төв, багийн төвд халуун усны төв байгуулна.

1.8 Сумын төвийн гудамж талбайд гэрэлтүүлэг хийх, камержуулах ажлыг үргэлжүүлэн хийж гүйцэтгэнэ.

ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИЛ ТОД, ШУУРХАЙ ЯВУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

2.1 Төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг авилга, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгаж, төрийн байгууллагын ажилчдын ур чадвар, чадавхийг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлнэ.

2.2 Мэргэжил эзэмшиж, төрөлх сумандаа ирж ажиллаж буй залуу боловсон хүчнийг ажиллах, амьдрах нөхцөл, бололцоог бүрдүүлнэ.

2.3 Иргэдийн сайн дурын үндсэн дээр зохион байгуулагдсан “Гамшгаас хамгаалах бүлэг” байгуулж, шаардлагатай сургалт, техник хэрэгслээр хангаж, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах ажлыг зохион байгуулна.

ГУРАВ. АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

3.1 Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулах замаар төр, хувийн хэвшил хамтарч ажиллаж, ажлын байр нэмэгдүүлнэ.

3.2 “Чинээлэг малчин”, “Шинэ хөдөө”, “Шинэ сум” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.3 ХАА-биржтэй малчдыг холбож, бүтээгдэхүүн, түүхий эдийг зах зээлд нийлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

3.4 Сумын нийт хүн амын хүнсний ногоог сумандаа тариалж, 4 улирлын хугацаанд хүнсний ногоогоор жигд хангах, хадгалах нөхцлийг бүрдүүлнэ.

3.5 Орон нутгийн онцлогийг шингээсэн аялал жуулчлалын хөтөлбөрийг боловсруулж, аялал жуулчлалын зам, маршрутыг гаргаж, газар дээр тэмдэгжүүлнэ.

3.6 Нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжих, гал түймэр, гамшигтай тэмцэх тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ.

ДӨРӨВ. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

4.1 Нийгмийн эмзэг бүлгийн хэсэгт шаардлагатай тусламж, дэмжлэг үзүүлнэ.

4.2 Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих ажлыг эрчимжүүлж, архидалт согтуурлын хор хөнөөлийг бууруулах ажлыг идэвхижүүлнэ.

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

5.1 Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын үйл ажиллагааг хянан шалгаж, шалгалтын үр дүнг нийтэд тайлагнана.



- 5.2 Сумын нутаг дэвсгэрийн агаар, ус, хөрсний бохирдолтой тэмцэж, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх асуудлыг журамлан зохион байгуулна.
- 5.3 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг батлуулж, ангилан ялгах, дахин боловсруулах, устгах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 5.4 Гол горхи, булаг шандны эх ундаргыг хамгаалалтанд авч, хамгаалалтын бүс байгуулна.
- 5.5 Ойн нөхөрлөл, иргэдийн мод үржүүлгийн аж ахуйг онцгойлон бодлогоор дэмжинэ.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:
АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНЫ ДЭД ДАРГА



А.БАТ-ИРЭЭДҮЙ

